

Хүүхдэд зориулсан Библи
танилцуулж байна

Иошуа
эрхийг
авсан нь



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: Janie Forest

Найруулсан: Ruth Klassen

Орчуулсан: Damdin Norolsuren

Бүтээсэн: Bible for Children
www.M1914.org

©2014 Bible for Children, Inc.

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



**Моше нас эцэслэв.
Иошуа Бурхан
түүнийг Израилийг
удирдуулахаар сонгосон
гэдгийг мэдэж байв.
Иошуа цэргээ
бэлдэхээсээ
өмнө
өөрийгөө
бэлдэж байлаа.**



**Бурхан Иошуад ялалтыг
өгөх болно гээд хэрэв
ард түмэн Бурханы
үгийн дагуу байвал
Бурхан өөрийн
амласан
газраа
ТЭДЭНД ӨГӨХ
БОЛНО ГЭВ.**



Тэгээд Израильчууд
Бурханыг үгэнд



дуулгавартай
байж
Иошуаг
дагах
болно гэж
тангараглажээ.



Шинэ удирдагч мэргэн
санаа олж Канаан



нутгыг
судлаад
Иерохо
хотын
хамгаалалтыг
шалгаад
ир хэмээн
туршуулуудыг
явуулжээ.





Израильчууд
анх тэнд
тулалдсан
ЮМ.





**Иерохогийн хаанд хотод
туршуул орж ирэв хэмээн хэл
хүрчээ. Хаан туршуулуудыг
олуулахаар цэргээ илгээв.**






Тэд хайсаар Рахабын гэрт ирсэн бөгөөд тэнд туршуулууд үнэхээр байсан юм. Цэргүүд гэрийг үүдийг тогшив. Рахаб хурдан гэгч нь маалинга доогуур тэднийг нуув.



Цэргүүдийг
явсны дараа
Рахаб олсоор
тэднийг доош
буулган хотоос
гаргав. Яагаад
энэ эмэгтэй
туршуулуудад
тусалсан бол?



Яагаад гэвэл
Бурхан тэдэнтэй
хамт байгааг тэр
мэдсэн юм. Тэр
эмэгтэй Бурхан
түүнийг аврахыг
хүссэн юм.
Туршуулууд
Рахаб болон түүний
гэр бүлийг аврахаа
амлажээ.




**Бурханы амласан канаан нутаг уруу
явахын тулд Иерохо орохын өмнө
Израильчууд Иордан голыг гатлах**




ХЭРЭГ ГАРАВ.



**Гэвч тэнд ямар ч гүүр байсангүй!
Хүмүүс голыг хэрхэн гаталсан бол?**




**Бурхан Иошуад хандан ард түмэн
болон цэргүүдийг тахилч нар
дагуулах ёстой бөгөөд тэд арван
хууль хийсэн гэрээний авдрыг
гартаа дамнан авч явах ёстой гэв.**




**Тахилч нар голын эрэгт ирэхэд
Бурхан гайхамшгийг үйлдэв.
Бурхан гол дундуур хуурай замыг
гаргав.**




**Ийнхүү бүх хүмүүс аюулгүй гарсны
дараа тэд арван хоёр том чулууг голд
тавиад бас өөр арван хоёр чулууг
Канаан голын эрэг дээр
байрлуулав. Эдгээр нь
ард түмэн хүүхдүүддээ
Бурханы агуу хүч
болон хайрыг
гэрчлэх дурсгал
болон үлджээ.**



Иерохо хот эргэн
тойрон маш бат
бөх хэрэмээр
хүрээлгдсэн
байлаа.





Дайралт Иошуагийн

төлөвлөсөнөөр

болсон бөгөөд


Бурхан өөрийн

ард түмний


төлөө ялалтыг

өгсөн ...





... ГЭДГИЙГ
Израилийн
шинэ удирдагчид
мэдүүлэхийн
тулд Бурхан
өөрийн
армийг
ТЭНГЭРЭЭС
ИЛГЭЭВ.





**Бурхан Иошуад хэрхэн Иерохог
дайрахыг зааж өгөв. Энэ нь маш
хачирхалтай төлөвлөгөө байлаа.**





**Бурханы ард түмэн хотын гадна
талаар тойрон алхах бөгөөд ингэхдээ
зургаан өдрийн турш өдөрт нэг удаа
тойрон алхана харин долоо дахь
өдөр долоон удаа тойрч алх.**









**Тэгээд тэд бүрээ үлээн
хашхирах ёстой, ингэвэл хотын
хана нуран унана! гэлээ.**



**Иошуа болон түүний цэргүүд
Бурханы тушааснаар хийв.
Магадгүй Иерохо хотын
хүмүүс тэднийг хараад
шоолон инээж
байсан байх.**





**Харин тэд долоон өдөр хэрмийг
тойрч алхсаны дараа тахилч
нар хуцын эврэн бүрээ
үлээхэд ард түмэн
хашхирав.**



Энэ үед Бурханы амлалт
биелэв ... ИЕРОХОГИЙН
АГУУ ХЭРМЭН ХАНА

БУТРАН
УНАВ!

7





Тэр хотоос зөвхөн
Рахабын гэр бүл
аврагдав. Тэр эмэгтэй
цонхноосоо час улаан
өнгийн тууз зүүжээ.





Иошуагийн хүмүүс
туузыг хараад Рахаб
болон түүний гэр
бүлийг хотоос
авч гарав.






Тэгээд Иерохо
хот Бурханы
тушааснаар
устгагдав.






Иошуа хотын алт,
мөнгө, эрдэнэсийг Бурханы
үйлчлэлд хэрэглэв. Тэгээд тэр
энэ нүгэлт хотыг дахин босгох
хэн болов ч хараагдсан гэв.






Удалгүй
Канаан нутгийн хүмүүс
Иерохо хот Иошнад хэрхэн
ялагдсан тухай сонсов.





Тэд Бурхан тэр
ард түмэнтэй хамт
байгааг ойлгов.



Иошуа эрхийг авсан нь
Бурханы үг Библээс авсан түүх

Иошуа 1-6

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."
Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг
бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж
хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж
хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь
үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир
Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн
өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг
зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс
дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та
Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал
гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр
таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн
та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.



**Хэрвээ та энэ үнэнд итгэж
байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй:
Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон
миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та
амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж
ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос
эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр
тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд
дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө
амьдрахад туслаач. Амен.**

**Библи уншиж өдөр бүр Бурхантай
ярилцаарай! Иохан 3:16**

